

МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАРИЛЦААГ ҮЕЧЛЭХ НЬ (1990 ОНООС ХОЙШ)

*Ц.Лхам**

1974 онд ХБНГУ, БНМАУ хоёр дипломат харилцаа тогтоосноос хойш эдүгээ хүртэлх Монгол-Германы харилцааг үечлэхийг оролдохдоо хоёр орны харилцааны түүхэн 30 гаруй жилийн хугацаанд гарсан томоохон өөрчлөлт, эргэлтийг баримжаалан гол шалгуураа болгосон билээ. Үүний дагуу доорх үндсэн үе шатууд тодорч байна.

1. Хоёр талын албан ёсны харилцааны эхлэл тавигдсан үе (1974-1985)
2. Хоёр талын соёлын хамтын ажиллагааны суурь тавигдсан үе (1986-1989)
3. Хоёр талын харилцаа идэвхжсэн үе (1990-1991)
4. Хоёр талын харилцаа шинэ агуулгаар баяжсан үе (1992-2005)
5. Хоёр талын харилцааны нэн шинэ үе (2006 оноос хойш)

1. Хоёр талын харилцаа идэвхжсэн үе (1990-1991)

1985 онд М.Горбачев өөрчлөлт, шинэчлэлтийн бодлого явуулахдаа Брежневийн номлолоос буюу социалист эрх ашгийн төлөө хүч хэрэглэхээс татгалзсанаар бий болсон түүхэн таатай нөхцөлд Германы ард түмний хүсэл зориг, удирдагчдынх нь дипломат ур чадвар, найз нөхдийнх нь дэмжлэгийн үрээр Германы хоёр улс 1990 оны 10 дугаар сарын 3-нд албан ёсоор нэгдсэн билээ. Германы нэгдэл ХБНГУ-ын гадаад, дотоод орчинг бүхэлд нь өөрчилсний зэрэгцээ шинэ үүрэг хариуцлагыг ч бас бий болгосон. Тухайлбал, үүнд хуучин БНАГУ-ын олон улсын гэрээнүүдийг хянаж биелүүлэх явдал орох юм.

Германы нэгдлийн гэрээний 6 дугаар бүлгийн 29 дүгээр зүйлд “БНАГУ-ын гадаад эдийн засгийн өргөн дэлгэр харилцаа, үүнд ялангуяа ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын өмнө хүлээсэн үүргийг итгэлцэн хамгаалах болно. Чингэхдээ оролцогч бүх талуудын сонирхлыг харгалзан үзэхийн зэрэгцээ зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчим, ЕХН-ийн эрх, үүргийг анхааран үзэж энэхүү харилцааг цаашид хөгжүүлж, өргөжүүлнэ. Нэгдсэн Германы Засгийн газар чиглэлийн ажил үүргийн хүрээнд энэ харилцааг цаашид зохион байгуулж, зохицуулахад санаа тавих болно”¹ гэжээ.

1990 оны 10 дугаар сарын 3-ны өдөр буюу Германы нэгдлийн баярын өдөр Холбооны Канцлер Др. Коль нэгдсэн Германы дипломат харилцаатай бүхий л дэлхийн орнуудын Засгийн газарт явуулсан

* Ц.Лхам - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

илгээлтдээ, “Бид Германы нэгдлийн явцад БНАГУ-ын олон улсын эрх зүйн гэрээнүүдийг үргэлжлүүлэх, өөрчлөх, хүчингүй болгох эсэхийг зохицуулж тодорхойлохын тулд итгэлцлийн хамгаалалт, оролцогч улсуудын сонирхлын байдал, ХБНГУ-ын гэрээгээр хүлээсэн үүрэг зэргийг харгалзан үзэж, чөлөөт, ардчилсан, эрх зүйт журмын зарчмын дагуу ЕХН-ийн эрх үүргийг анхааран үзэж БНАГУ-ын олон улсын эрх зүйн гэрээнүүдийг гэрээт түншүүдтэйгээ нарийвчлан хэлэлцэх болно”² гэжээ.

Харин БНМАУ-ын хувьд авч үзвэл хуучин БНАГУ-тай дипломат харилцаа тогтоосноос хойш 40 шахам жилийн хугацаанд улс төр, эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагаа, соёл, боловсролын салбарт тус улстай тун эрчимтэй, ойр дотно харилцаатай байв. Эл хугацаанд хоёр талаас нэг нэг удаа дээд хэмжээнд харилцан айлчилсан бөгөөд 1986 онд БНАГУ-ын төлөөлөгчид айлчлах үеэр БНМАУ, БНАГУ-ын эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг 2000 он хүртэл үргэлжлүүлэх урт хугацааны гэрээнд гарын үсэг зурсан байв. Хоёр тал 1960 оноос эхлэн харилцан бараа нийлүүлэх тухай удаан хугацааны худалдааны хэлэлцээрийг тав таван жилийн хугацаатайгаар сунган байгуулсаар иржээ. БНМАУ нь ЭЗХТЗ-ийн гишүүний хувьд БНАГУ-аас хөгжлийн тусламж хүртэх 1-р ангиллын оронд багтаж,³ 1958-1990 хүртэлх хугацаанд 20000 орчим оюутан, аспирант, мэргэжилтнээ БНАГУ-д үнэ төлбөргүйгээр сургаж, мэргэжил дээшлүүлсний зэрэгцээ Мах комбинат, Хивсний үйлдвэр, Борнуурын сангийн аж ахуйн иж бүрэн цогцолборыг БНАГУ-ын буцалтгүй тусламжаар барьж байгуулан, тэдгээрийн засвар, шинэчлэл, мэргэжил дээшлүүлэх сургалт зэргийг үргэлжлүүлэн тус улсын дэмжлэгтэйгээр явуулсаар ирсэн байв. Мөн Улаанбаатарын Шаазан, ваарны үйлдвэрийн өргөтгөлийг хийж, Улаанбаатарын хэвлэлийн комбинатын гүн хэвлэлийн цехэд тоног төхөөрөмж зэргийг тусламжаар нийлүүлсэн байдаг. Үүнээс гадна Монголын ашигт малтмалын орд газрыг нээн илрүүлэх, малын паразиттай тэмцэх био бэлдмэл бэлтгэх зэрэг төслүүдийг хамтран хэрэгжүүлж байжээ.⁴

Энэхүү хамтын ажиллагааны баялаг өвийг Германы нэгдлийн дараа ХБНГУ залгамжлан цааш хөгжүүлэхэд хуучин БНАГУ, БНМАУ-ын хооронд байгуулагдсан хүчинтэй гэрээ хэлэлцээрүүдийг зах зээлийн эдийн засгийн нөхцөлд хэрэглэх боломж магадгүй хомс байсан тул хуучин хамтын ажиллагааны төвшинг аль болох бууруулахгүй байх бодлогыг баримталсан бололтой. Үүний үр дүнд хуучин БНАГУ-ын Улаанбаатар хот дахь ЭСЯ-ны барилга байшинг ашиглан ХБНГУ-ын ЭСЯ-ыг 1990 онд нээсэн.⁵ Тухайн үед БНАГУ-ын их, дээд сургуулиудад суралцаж байсан монгол оюутнуудад сургуулиа төгсөх хүртэл тэтгэлгийг ХБНГУ-ын Засгийн газраас үргэлжлүүлэн олгосон байна. Мөн 1988 онд байгуулагдсан *Соёлын хамтын ажиллагааны протокол*

ын хугацаа 1990 онд дуусгавар болсон тул 1991 оны 6 дугаар сарын 21-нд ХБНГУ, БНМАУ-ын Засгийн газар хооронд *Соёлын хамтын ажиллагааны протокол*-ыг шинэчлэн байгуулсан. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн зарчмаар зохицуулагдах худалдааны хэлэлцээрийг зах зээлийн эдийн засгийн нөхцөлд үргэлжлүүлэх боломжгүй байсан тул ХБНГУ санаачлан өөрийн зардлаар 1991 оны 5 дугаар сард БНМАУ-д худалдааны семинар, 1992 оны 7 дугаар сард ХБНГУ-ын Эдийн Засгийн Яам, Германы экспортлогчдын холбооноос санаачлан ажил хэргийн уулзалт зохион байгуулж, Монголын барааг ХБНГУ, ер нь Европт экспортлоход анхаарах зүйлийн талаар Монголын худалдааны хүмүүст зөвлөгөө өгч, бизнесменүүдийг хооронд нь уулзуулж холбож өгсөн байна. Харин бусад хамтын ажиллагааг цааш хэрхэн үргэлжлүүлэх нь Монголын талын бодлого, байр сууриас ч мөн хамааралтай байв.

1990 оны эхэн үед БНМАУ-ын гадаад, дотоод нөхцөл байдал бүрмөсөн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хоёр талын харилцаанд доорхи томоохон үйл явдлууд болжээ. Үүнд, тухайлбал:

- *Дотоод орчны өөрчлөлт*: ЭЗХТЗ татан буугдаж, ЗХУ задарснаар БНМАУ-ын хувьд гадаад зээл, тусламжийн эх үүсвэр үгүй болж, эдийн засгийн уналт 1990 оноос хэдийнээ эхэлсэн байв. Гэтэл энэ үед БНМАУ ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих хос шилжилтийг хийж эхлэхдээ “цочир муужруулах эмчилгээ”-ний аргыг 1991 онд сонгосноор эдийн засгийн уналтыг бүр хурцатгаж гүнзгийрүүлж орхисон. Эдийн засгийн уналтын оргил үе болох 1992 онд инфляци 325%, эдийн засгийн уналт 9%-д хүрсэн байв.⁶ Иймд 1990-ээд оны эхний жилүүдэд эл дотоод тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд Монгол Улсад гадны зээл, тусламж нэн шаардлагатай байлаа.

- Монгол Улс эдийн засгийн дотоод тулгамдсан асуудлын улмаас 1990 онд ХБНГУ-аас их хэмжээний хөнгөлөлттэй зээл авах хүсэлт тавьсны хариуд ХБНГУ хүнсний болон бусад яаралтай тусламж үзүүлэх болсны зэрэгцээ хоёр талын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааг 1991 оноос эхлүүлэхээр болжээ. Хоёр орны хөгжлийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг эдийн засгийн шинэчлэлийг хөхиүлэн дэмжих, хувийн хэвшлийг хөгжүүлэх хэмээн тодорхойлсон ч 1991 оны хувьд олгохоор шийдвэрлэсэн 24 сая ДМ-ийн зээл, тусламжийн бараг 40% (10.3 сая ДМ)-ийг БНАГУ-ын үед хэрэгжүүлж байсан хуучин төслүүдийг үргэлжлүүлэхэд зарцуулахаар тохирсон байдаг.

- *Гадаад орчны өөрчлөлт*: 1990, 1991 онд социалист хамтын нөхөрлөл үгүй болж, ЗХУ задран унаснаар БНМАУ сул чөлөөтэй болж, бие даасан гадаад бодлого явуулах боломжтой болсон. БНМАУ газар зүйн хоёрхон хөршийнхөө нэг болох Хятадаас түүхэн тодорхой шалтгааны

улмаас зай барьж байхын зэрэгцээ нөгөө нэг хөрш болох ЗХУ-аас сүүлийн 70 жилийн туршид хэт хамааралтай байсан гашуун түүхээс сургамж авч, шинэ гадаад бодлогодоо хоёр хөршийнхөө нөлөөг аль болох багасган тэнцвэржүүлэхэд чиглэсэн “олон тулгуурт бодлого”-оо боловсруулсан. Монгол Улс өөрийн газар зүйн хавчигдмал орчноос үүдэлтэй улс төрийн хязгаарлагдмал орчиндоо нэмэлт таатай нөхцөл бүрдүүлэхийн тулд гадаад болон аюулгүйн бодлогын олон төрөл, олон тулгууртай, олон идентификацтай байх нь зүйтэй юм гэсэн “олон тулгуурт бодлого”-ынхоо хүрээнд 1991 онд Гадаад хэргийн сайд Ц. Гомбосүрэн, өрнийн өндөр хөгжилтэй орнуудыг Монголын гадаад, аюулгүй байдлын бодлогын гурав дахь тулгуур багана мөн гэж үзсэн байна.⁷ Иймд ХБНГУ нь Монголын гадаад, аюулгүй байдлын бодлогод чухал байр суурийг эзлэх болж, Монголын тал ХБНГУ-тай харилцах харилцаанд урьд урьдынхаас илүүтэй ач холбогдол өгөх болсон нь тухайн үеийн Монголын Засгийн газруудын хөтөлбөрт ч тусгалаа олсон байна.⁸

Харин эл чиг хандлага Монгол-Германы харилцаанд хэрхэн илэрснийг авч үзье. Жишээлбэл, Монголын анхны ардчилсан сонгуулиар сонгогдсон УИХ-д 1991 оны 3 дугаар сарын 28-нд Монгол-Германы Парламентын бүлгийг тусгайлан байгуулсан явдал болно. Монгол Улсын Гадаад хэргийн сайд Ц.Гомбосүрэн 1991 онд, Ерөнхий Сайд Д.Бямбасүрэн 1992 онд, УИХ-ын дарга Н. Багабанди 1993 онд ХБНГУ-д тус тус айлчилж, Монгол Улс нь ХБНГУ-ыг Европ дахь улс төр, эдийн засгийн гол түнш хэмээн үзэж байдгийг дахин нотолж, манай Засгийн газрын энэхүү байр сууринд ХБНГУ-ын Засгийн газрын анхаарлыг хандуулахыг зорьсон байна.

Хэдийгээр энэ үе шат эхлээд тун удаагүй байсан ч 1992 оноос Монгол-Германы харилцаа хуучин БНАГУ, БНМАУ-ын харилцааны уламжлалаас давж, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа эхэлсэн нь хамтын ажиллагааны шинэ үе шат эхэлснийг илтгэх болсон.

2. Хоёр талын харилцаа шинэ агуулгаар баяжсан үе (1992-2005)

1990 оны Германы нэгдлийн үр дүнд ХБНГУ нь эдийн засгийн чадавхи, хүн амын тоо, геополитикийн төвийн байрлал зэргээрээ Европт давуу байдалтай болсны зэрэгцээ бүрэн эрхт байдлаа эргүүлэн авсан. Иймд ХБНГУ эзэлж буй байр суурьтайгаа дүйцэх хэмжээний үүрэг хариуцлагыг дэлхий нийтийн өмнө хүлээхийг бусад улс орнуудын зүгээс шаардах болсон⁹ төдийгүй ХБНГУ-ын зүгээс ч үүнийг хүлээн зөвшөөрч, дэлхийд энх тайван, ардчиллыг тогтоох үйл хэрэгт хувь нэмрээ оруулах явдлыг өөрийн нэг үүрэг хэмээн тодорхойлох болсон. 1990 оны нэгдлийн дараа Үндсэн хуулийнхаа шинэчлэн найруулсан оршил хэсэгтээ “ХБНГУ

нь нэгдсэн Европын эрх тэгш гишүүн болохынхоо хувьд дэлхийн энх тайвны үйл хэрэгт оролцох үүрэг хүлээх”¹⁰ болсон.

Ийнхүү ХБНГУ-ын гадаад, аюулгүй бодлогод дэлхийн энх тайван, ардчилалд хувь нэмрээ оруулах шинэ үүрэг хариуцлага бий болоод байсан энэ үед Европын Холбооны зэргэлдээ хямрал, тогтворгүй байдал бүхий нэгэн шинэ бүс бий болж, тэр зүг ХБНГУ-ын анхаарал хандаж эхэлсэн.

1991 онд ЗХУ задран унах үед улс төр, эдийн засгийн хувьд бүрэн төлөвшөөгүй, хямралтай, дотооддоо болон хоорондоо янз бүрийн зөрчил мөргөлдөөний их, бага голомт бүхий олон шинэ тогтворгүй улсууд бий болсон. Тэдгээр шинээр тусгаар тогтносон улсуудын Кавказ, Төв Ази дахь хэсэг нь

- Хэдийгээр Европын Холбоотой хиллээгүй боловч миграц, мансууруулах бодисын наймааны урсгал тус бүсээр дамжин Европ руу чиглэх болсон нь Европын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байв. Мөн тэдний дотоодын дайн самуунд ОХУ болон бусад гуравдагч орнууд хөндлөнгөөс оролцсон тохиолдолд Европын аюулгүй байдал хөндөгдөнө гэсэн болгоомжлол оршиж байсан нь хожим 1995 оны Европын Комиссын мэдэгдэлд тусгалаа олсон байна.¹¹

- эрчим хүчний арвин баялаг нөөцөөрөө ХБНГУ, Европын Холбоо төдийгүй дэлхийн томоохон гүрнүүдийн анхаарлыг татаж байв.¹² Тухайлбал, 1990 онд Европын Холбоо Каспий орчмын нутгийг “Бүх Европын сонирхол”-ын бүс хэмээн зарласныг¹³ 1990 оны Европын Хамтын Нийгэмлэгийн Парисын хартаас үзэж болно. Мөн ХБНГУ 1992 онд гаргасан батлан хамгаалах бодлогын чиг баримтлалд “Германы бодлого нь дэлхийн эдийн засгийн шударга журмын үндсэн дээр дэлхий нийтийн худалдааг хамгаалах, түүхий эд болон дэлхийн зах зээлд саадгүй хүрэх язгуур ашиг сонирхлоо хэрэгжүүлэхийг удирдлага болгоно”¹⁴ хэмээн заасан байдаг.

Үүнээс үзэхэд, ХБНГУ нь Төв Азийн эрчим хүчний нөөцөд нэвтрэх, чингэхийн тулд эхлээд тэнд тогтвортой байдал бий болоход дэмжлэг үзүүлэх бодлого баримтлах үндэслэлтэй юм. Гэвч тухайн үед Төв Азид байдал тун ээдрээтэй, Тажикстанд 1992 онд иргэний дайн эхэлсэн, бүгдэд нь Ерөнхийлөгчийн дарангуйллын дэглэм төлөвшин тогтож буй тийм бүс нутагтай шууд үр дүнтэй хамтран ажиллах боломж бага байх тэр үед газар зүйн байрлалын хувьд Төв Азийн бүсэд орших Монгол Улс ганцаараа доорхи зүйлүүдээр бусдаасаа ялгарч байв. Үүнд:

- 1990 онд ардчилсан хувьсгалыг тайван замаар явуулж, социалист дарангуйллын дэглэмийг түлхэн унагаснаас гадна ардчилсан сонгууль шударга явагдаж, парламентын ардчилсан тогтолцоог сонгож авснаас хойш улс төр, эдийн засгийн хос шилжилтийг тууштай хийж байснаараа тухайн үеэс Монгол Улс нь шилжилт хийж буй орнуудын

дотор харьцангуй үлгэр жишээ болж байлаа. Монгол Улс ийнхүү улс төрийн тогтвортой байдлаа хадгалснаар тухайн үедээ бүс нутагтаа тогтвортой байдлын нэг хүчин зүйл болж байв.

- Монгол Улс 1990 оноос хойш идэвхитэй, нээлттэй гадаад бодлого явуулж байсан нь бүс нутагтаа аюулгүй байдал, тогтвортой байдал, итгэлцлийг бэхжүүлэхэд хувь нэмэр болж байв. Тухайлбал, 1992 онд Монгол Улс нь нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлаж,¹⁵ Үүнийг цаашид цөмийн зэвсэгтэй их таван гүрнээр хүлээн зөвшөөрүүлж, баталгаа гаргуулж чадсан байна. Монгол Улс нь Төв Ази төдийгүй Зүүн Хойд Азийн бүс нутгийн аль ч улстай найрсаг харилцаатай, бүс нутгийнхаа аль ч улстай ямар нэгэн газар нутгийн маргаан, томоохон зөрчилгүй цорын ганц улс болохын хувьд цаашид бүс нутагтаа хамтын ажиллагааг хөгжүүлэхэд зуучлагчийн үүрэг гүйцэтгэхэд нэн тохиромжтой байв.

Монгол Улс ийнхүү Төв Азийн тогтвортой байдлыг хангахад оруулж буй хувь нэмэр нь ХБНГУ-ын Төв Ази дахь сонирхолд нийцэж, цаашдаа ч Монгол Улс энэ бүс нутагт илүү их үүрэг рольтой байхыг Германы тал хүсэн хүлээсэн байж болох талтай. Монгол Улс цаашдаа энэхүү хувь нэмрээ хадгалан бататгах, өсгөн нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх явдал бол эцсийн дүндээ Төв Азийн бүс нутгийн тогтвортой байдлыг хангахад эерэг нөлөөтэй хэмээн Германы тал үзэж, Монгол Улс дахь ардчилал, шинэчлэлийн үйл явцад хүчтэй дэмжлэг үзүүлэх бодлого чиглэлийг ХБНГУ-ын тал 1992 оноос хойш баримталж буй болов уу. Нөгөөтэйгүүр тухайн үед хөл дээрээ дөнгөж зогсож буй Монголын нялх ардчиллыг сайтар түшиж, өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцыг дэмжих нь ХБНГУ-ын хувьд дэлхийн энх тайван, ардчилал, хүний эрх, эрх зүйт ёсны төлөө оруулж буй нэр хүндтэй хувь нэмэр төдийгүй Германы нэгдлийн дараа дэлхий нийтийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан биелүүлж буй хэлбэр ч гэж үзэж болох юм. ХБНГУ-ын эл бодлого хоёр талын харилцааны практикт хэрхэн хэрэгжсэнийг одоо авч үзье.

1. Улс төр, парламентын харилцаа: Монгол Улсад Холбооны Ерөнхийлөгч Роман Херцог 1998 онд, Холбооны Гадаад хэргийн сайд Клаус Кинкель 1996 онд, Холбооны Бундестагийн Дэд Ерөнхийлөгч Д.Ю.Кроненберг 1991 онд, Бурхардт Хирш 1999 онд, Антьеэ Фольмер 1999 онд, 2003 онд Монголд тус тус айлчилсан. Дэд Канцлер К.Кинкель хоёр талын харилцааг “идэвхтэй, сайн харилцаа” гэж үнэлсэн бол Р.Херцог “Герман-Монголын харилцаа бол онцгой итгэмжилсэн харилцаа” гэж дүгнэсэн байна. Ерөнхийлөгч Херцог энэ айлчлалын үеэр “Монгол Улс нь умард, өмнөд их хөршүүд болон Төв Азийн шинэ орнуудтай яриа хэлцээний идэвхтэй бодлого явуулах замаар түншийн тогтвортой харилцаа тогтоож, урьдын хурцадмал байдлыг шинэ итгэлцлэлээр солихыг эрмэлзэж буйг бид сэтгэл нэн

ханамжтай ажиглан харж байдаг”¹⁶ гэж хэлсэн нь Германы бодлогыг тодорхой хэмжээгээр харуулж байна.

2. Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа: Бээжинд суугаа Германы ЭСЯ-ны цэргийн атташе, Бундесверийн Ерөнхий штабын хурандаа Шрөтер 1992 онд Монгол Улсад айлчилснаар хоёр тал анх холбоо тогтоож эхэлсэн. Улмаар 1993 онд Монгол Улс, ХБНГУ-тай цэргийн дипломат харилцаа тогтоож, 1994 оноос ХБНГУ-аас Монгол Улсад (хавсран) суух цэргийн атташе албан ёсоор ажилдаа орсон байна. 1995 онд Холбооны БХЯ дахь Парламентын төрийн нарийн бичгийн дарга Бернд Вильцийн Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр “Бундесверийн Цэргийн сургуульд Монголын цэргийн боловсон хүчнийг сургаж, цэргийн боловсролын салбарт тусламж үзүүлэх тухай Монгол Улсын БХЯ, ХБНГУ-ын БХЯ хоорондын гэрээ”, “Монгол Улс, ХБНГУ-ын БХЯ-дын хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл”-д тус тус гарын үсэг зурсан байна.¹⁷ ХБНГУ Монголын зэвсэгт хүчин ардчилсан нийгэмд байр сууриа олоход нь дэмжлэг үзүүлэх, ялангуяа боловсон хүчний сургалт, семинар, мэргэжил дээшлүүлэх асуудалд гол анхаарлаа хандуулж байгаа нь ажиглагдаж байна.

3. Эдийн засгийн хамтын ажиллагаа: Энэ үе шатанд хоёр талын эдийн засгийн харилцааны үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд Германы тал Монгол Улсад Хермесийн баталгааг олгох, ЭЗХАХБ-д Монгол Улсын зэрэглэлийг ахиулах санаачлага гаргах гэх мэт арга хэмжээг авч байна. Мөн үүнээс гадна Монгол, Германы тал хамтран эдийн засгийн өдөрлөг, эдийн засгийн уулзалт, форум, соёлын өдөрлөг, үзэсгэлэн зэрэг 20 гаруй арга хэмжээг хамтран зохион байгуулсан байна.

4. Хөгжлийн хамтын ажиллагаа: ХБНГУ 1992-2006 онд 210.5 сая еврогийн хөгжлийн албан ёсны тусламж үзүүлсэн. Мөн үүний зэрэгцээ Конрад Аденауэрын Сан, Ханнс Зайделийн Сан, Фридрих Эбертийн Сан, Интеграццилагдсан мэргэжилтнүүд (СИМ), Германы Хөгжлийн Алба (ДЕД), Германы аж үйлдвэрийн ахмад мэргэжилтнүүдийн үйлчилгээ (SES), Карл Дуисбергийн Нийгэмлэг, Олон улсын хөгжлийн Германы сан (DSE) зэрэг ТББ-ууд хөгжлийн албан ёсны бус тусламжийг Монголд үзүүлсээр байна.

7. Соёлын хамтын ажиллагаа: Хоёр тал 1991 оны Соёлын протоколыг 1995 онд дахин шинэчилж, 1997 онд Соёлын шинэ хэлэлцээр байгуулж, Соёлын протоколыг 2002 онд байгуулсан. Уг бичиг баримтуудыг хэрэгжүүлэх үйл явц соёлын хөтөлбөрт ажлууд, ДААД болон бусад судалгааны сангуудын үйл ажиллагаа, хотуудын түншлэл, залуучууд, хэвлэл мэдээллийн болон спортын хамтын ажиллагаа гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй явагдаж байна.

Монгол Улсын бүс нутгийнхаа тогтвортой байдалд оруулсан тодорхой хэмжээний хувь нэмэр энэ зууны эхэн үеэс ХБНГУ болон Европт эерэг нөлөөг үзүүлсэн бололтой. 2000-аад он гарахад Төв Азийн орнууд хэдийгээр ардчилсан бус ч байдал нь харьцангуй тогтворжсон. Эл байдлыг ХБНГУ ашиглах болсон. 2003 онд Холбооны Канцлер Герхард Шрёдер Казахстанд айлчилж, хоёр орны харилцаа дээд төвшинд хүрч, ХБНГУ Казахстангаас 2005 оны 8 дугаар сараас 2006 оны 7 дугаар сар хүртэл 7.458 сая.тн түүхий нефть (2005/VIII-2006/VII хугацаанд түүхий нефтийн нийт импорт ХБНГУ-д 111.565 сая.тн) импортолсон нь Германы эл төрлийн импортонд 5 дугаар байрыг эзлэх болжээ. Ийнхүү Төв Азийн эрчим хүчний нөөцөд нэвтрэх гарц ХБНГУ-д тодорхой хэмжээгээр нэгэнт бүрэлдэн бий болж эхэлжээ.

Өөр нэг жишээ дурдъя. 2001 онд Хятад, Орос болон Төв Азийн орнуудыг эгнээндээ нэгтгэн байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад Монгол Улс 2004 оноос ажиглагчийн статустай оролцож байна. Терроризм, сепаратизм, экстремизмын эсрэг тэмцэх эл байгууллагыг дэмжих хандлага Европт бий¹⁸ гэж үзвэл ардчилсан улсын нэг болохын хувьд Монгол Улс нь ШХАБ-д улам идэвхтэй оролцохыг хүсэн хүлээсэн байж магадгүй. Энэ үе шатанд Монгол дахь ардчилал, шинэчлэлийн үйл явц, Монголын Төв болон Зүүн Азийн бүс нутагт оруулж буй хувь нэмэр, эзэлж буй байр суурь ХБНГУ-ын үүднээс авч үзэхэд хоёр орны харилцааг тодорхойлогч шинж чанартай байжээ гэж хэлж болохоор байна. Харин одоо Монголын талын байр сууринаас хоёр талын хамтын ажиллагааг авч үзье.

1990-ээд оны эхэн үеэс баримтлах болсон Монголын “олон тулгуурт гадаад бодлого”-ын үзэл санаа 1994 оны Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд тусгагдахдаа өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнууд гуравдугаар байрнаас дэвшиж хоёрдугаар байранд орох болжээ. Уг үзэл баримтлалд зааснаас үзэхэд, Монгол Улс нь ХБНГУ-ыг хоёр хөрш орны дараа орохуйц, АНУ, Японтой дүйцэхүйц гадаад бодлогын тэргүүлэх хоёр дахь чиглэлийн орон буюу Европ дахь гол түншээ гэж үзсэн байна. Мөн ХБНГУ-тай найрсаг харилцааг хөгжүүлж, түүний эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгон зохистой түвшинд хүргэх бодлого баримтална гэжээ.¹⁹ Ийнхүү ХБНГУ-ын ач холбогдол шат ахин нэмэгдсэнтэй холбоотойгоор Монголын ХБНГУ-д чиглэсэн бодлого ч энэ үеэс дахин идэвхижиж, Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат 1995 онд ХБНГУ-д айлчлал хийхдээ, Монголын талын санаачилсан “Монгол Улс, ХБНГУ-ын харилцааны үндсийн тухай хамтарсан тунхаглал”-д хоёр тал гарын үсэг зурсан байна. Энэхүү хамтарсан тунхаглалд хоёр тал цаашид эдийн засаг, соёл, хэвлэл мэдээлэл, цэрэг-улс төр, олон улсын гэмт хэрэг,

олон улсын аюулгүй байдлын салбар болон НҮБ-ын хүрээнд хамтран ажиллахдаа ямар зарчмыг удирдлага болгох, юуг зорьж эрмэлзэх тухай тодорхойлон заасан байдаг. Тухайлбал, уг хамтарсан тунхаглалд, “Хоёр тал эдийн засгийн салбарт эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллахыг чухалчилна” хэмээсэн байдаг. Өрнөдийн орнуудтай харилцан ашигтай хамтран ажиллах тухай нэр томъёо Монголын нэн шинэ үеийн гадаад бодлогын түүхэнд анхлан 1988 онд үзэгдэх болсноос²⁰ хойш 1995 оны дээрх тунхаглалд Монгол-Германы эдийн засгийн хамтын ажиллагааны чухал нэгэн зорилт болон бичигдэх хүртлээ байнга хэрэглэгдэж, утга агуулгын хувьд ч тодотгогдсоор иржээ. Одоо тэдгээрт дулдуйдан дэлгэрүүлэн тайлбарлахыг оролдъё.

Монгол-Германы харилцан ашигтай, хамтын ажиллагаанд хүрэхийн тулд ХБНГУ-ын эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгон зохистой түвшинд хүргэх бодлогыг Монголын тал баримтлах²¹ шаардлагатай ажээ. Тодруулбал, нэг талаас Монгол орны эрдэс баялаг, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн боломж, нөгөө талаас Германы капитал, хөрөнгө оруулалт хийгээд тэргүүний техник, технологи, менежмент нь хоёр талаас хамтарч харилцан ашигтай хамтын ажиллагааг үүсгэж болох бөгөөд чингэхийн тулд Монголын эрдэс баялгийн томоохон ордыг ашиглах, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах том үйлдвэрүүд байгуулахад Германы талын ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтыг Монголд татаж оруулж чадсан нөхцөлд энэ хөрөнгө оруулалт нь Монголд дахь ХБНГУ-ын эдийн засгийн болон бодит сонирхлыг харуулж чадах ажээ. Монгол-Германы харилцаанд харилцан ашигтай хамтран ажиллах тухай ойлголт цэгцрэх явцад бүхий л салбарт зүйл бүрээр хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай яригдах болж,²² агуулгын хувьд баяжин гүнзгийрсээр 2002 оноос “иж бүрэн түншлэл” хэмээн нэрлэгдэж, Монгол-Германы харилцааны шинэ зорилт болон гарч ирсэн.

2002 онд Ерөнхий сайд Н.Энхбаяр ХБНГУ-д айлчлах үедээ “ХБНГУ-ын Холбооны Ерөнхийлөгч Роман Херцог хэдэн жилийн өмнө манай оронд айлчлахдаа хоёр орны харилцааг чин сэтгэлийн итгэмжилсэн харилцаа хэмээн тодорхойлсон юм. Бид хоёр орны энэхүү итгэмжилсэн сайн харилцааг XXI зуунд чиглүүлэн иж бүрэн түншлэлийн харилцаа болгон хөгжүүлж гүнзгийрүүлэхийг зорьж байна... Иж бүрэн түншлэл гэдэг ойлголтын хүрээнд харилцаа, хамтын ажиллагаагаа бүх салбарт өргөжүүлэн хөгжүүлэхийг сонирхож байгаа эрмэлзлээ бид ухаардаг”²³ хэмээн мэдэгдсэнээр хоёр талын харилцааг иж бүрэн түншлэлд хүргэх шинэ зорилт нэмэгдэх болсон. 1990 оны Бейкерийн айлчлалаас улбаатай “гурав дахь хөрш”-ийн нэр томъёо 2006 оноос Монгол-Германы харилцаанд үзэгдэх болсон. Монгол Улсын хувьд “гурав дахь хөрш” гэдэг нь эдийн засгийн төдийгүй бусад бодит сонирхлынхоо үндсэн дээр газар

зүйн хөршийн нэгэн адилаар Монгол Улстай гүн батаар холбогдон уягдаж, “иж бүрэн түншлэл”-ийн хэмжээнд харилцан ашигтайгаар хамтран ажиллаж буй улс байх магадлалтай юм. Ингээд практик алхмуудаас үзэхэд Монгол Улс нь ХБНГУ зэрэг “иж бүрэн түншлэл”-д хүрэхийг чармайж буй бүх улсад “гурав дахь хөрш”-ийн бодлогоо дам явуулж буй гэж үзэж болох болов уу. Монгол-Германы харилцаанд Монголын талаас баримталсан харилцан ашигтай хамтран ажиллах, “иж бүрэн түншлэл”-д хүрэх, “гурав дахь хөрш”-өө болгох бодлогын хүрээнд 1992 оноос хойш ямар ямар алхмуудыг хийсэн тухай бодит үр дүнгээс авч үзье.

1. Улс төр, парламент, цэргийн харилцаа: 1992 оноос хойш Монгол Улсын Ерөнхийлөгч 2 удаа,²⁴ Ерөнхий сайд 3 удаа,²⁵ Гадаад хэргийн сайд 3 удаа,²⁶ Монголын УИХ-ын дарга 3 удаа,²⁷ УИХ-ын дэд дарга 3 удаа,²⁸ Батлан хамгаалахын сайд 1 удаа,²⁹ БХЯ-ны ТНБД 3 удаа³⁰ ХБНГУ-д тус тус айлчилж, ХБНГУ нь Монгол Улсын хувьд чухал түнш болохоо нотолсон байна.

2. Эдийн засгийн хамтын ажиллагаа: Монгол Улс, ХБНГУ-ын хоорондын хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай гэрээнд хоёр тал 1991 онд, Орлогын болон хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх тухай хэлэлцээрт 1994 онд тус тус гарын үсэг зурсан. ХБНГУ-ын зүгээс 1990-2007 он хүртэл 12 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн нь Монгол Улсад орж ирсэн нийт хөрөнгө оруулалтын 0.6%-ийг эзэлж, 17 дугаар байранд орж байна. Германы хөрөнгө оруулалтын 34.9% нь худалдаа, нийтийн хоол, 20.1% нь хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 6.1% нь мебель, модон эдлэл, 4.7% аялал жуулчлал, 3.4% барилга, 2.8% нь ХАА, газар тариалан, МАА-н салбар, 2.0% нь мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт, 19.5% нь бусад салбарт зэрэг ангилалд багтсан байна. Монгол-Германы худалдааны эргэлт 1990 онд 25.7 сая ДМ байсан бол 2006 онд 57.9 сая евро болж өссөн байна. 2006 онд Монгол-Германы худалдааны эргэлт Монголын нийт худалдааны эргэлтний 1.9%-ийг эзэлж байв. Хоёр талын худалдаанд Германы тал ихэвчлэн ихээхэн ашигтай байдаг байна. Манай улсаас ХБНГУ-д экспортлодог барааны 60 гаруй хувийг өлөн гэдэс, самнасан ноолуур, ноолууран сүлжмэл, импортлодог барааны дийлэнхийг хүнсний зүйл, пиво, дарс, машин, тоног төхөөрөмж, ачааны болон хөнгөн тэрэг, мебель зэрэг бараа эзэлж байна.³¹

3. Соёл, боловсролын хамтын ажиллагаа: Герман хэлний гүнзгийрүүлсэн сургалттай Монгол-Германы хамтарсан 38 дугаар сургууль 1999 оноос, Гёте хувийн дунд сургууль 2002 оноос тус тус Монголд ажиллаж байна. 1999 онд Германы их, дэд сургуулиудад нийтдээ 719 монгол оюутан суралцаж байсан бол 2000 онд 29%-иар нэмэгдэж оюутны тоо 929, 2003 онд 1400³² хүрсэн байна.

3. Хоёр талын харилцааны нэн шинэ үе (2006 оноос хойш)

Дэлхийн нийтийн эдийн засгийн өсөлт, ялангуяа АНУ, Хятадын эдийн засгийн өсөлт, хоёрдугаарт, Хятад, Энэтхэг тэргүүлэн эрчимтэй хөгжиж буй орнуудын эрчим хүчний хэрэглээний эрс өсөлт, гуравдугаарт, эрчим хүчний түүхий эд нийлүүлэгч орнуудын улс төрийн тогтворгүй байдалтай холбоотойгоор дэлхийн зах зээл дээр нефть болон эрчим хүчний бусад түүхийн эдийн үнэ 2004, 2005 онд огцом нэмэгдсэн байна. 2004 онд нефть, нүүрсний үнэ 2002 оны үетэй харьцуулахад бараг 50%-иар нэмэгдсэн бол ураны үнэ бараг 150%-иар нэмэгдсэн байна.³³ Үүнээс гадна энэ үед дэлхийн эдийн засгийн өсөлтийн улмаас зэс, алт, мөнгө зэрэг үнэт металлын үнэ ихээр нэмэгдэх болсон байна.

Ийм нөхцөлд Эрчим хүчний аюулгүй байдлын асуудал сүүлийн жилүүдэд ХБНГУ-д төдийгүй Европын Холбооны хүрээнд тулгамдсан асуудлын нэг болоод байна. 2006 оны 3 дугаар сарын 8-нд Европын Холбооны Комиссоос Ногоон ном буюу байнгын, өрсөлдөх чадвартай, найдвартай эрчим хүчний стратеги гэсэн бичиг баримтыг гаргасан. Хэрвээ европчууд эрчим хүчний үйлдвэрлэлээ өрсөлдөх чадвартай болгож чадахгүй байх аваас 2026-2036 он гэхэд Европын Холбооны орнууд эрчим хүчний нийт хэрэглээнийхээ 70% (2006 оны байдлаар 50%)-ийг импортоор авдаг болох ажээ.³⁴ Иймд Европын Холбооны улсууд эрчим хүчний нэгдсэн гадаад бодлого баримталж, эрчим хүчний хангамжийг олон талтай болгох, бататгах тодорхой үзэл баримтлалыг боловсруулах шаардлагатай хэмээн Ногоон номонд онцолсон байна. Гэтэл эрчим хүчний эх үүсвэр цөөхөн хэдэн оронд төвлөрдөг бөгөөд тэдний нэлээдэд нь улс төрийн тогтворгүй байдал ноёрхож байна.

Энэ үед улс төрийн хувьд тогтвортой, ардчилсан Монгол Улс төрөл бүрийн ашигт малтмалын арвин баялаг нөөцөөрөө ялангуяа дэлхийд дээгүүрт тооцогдох зэс, алтны их хэмжээний нөөц бүхий Оюу толгой, их хэмжээний коксжих нүүрсний нөөцтэй Таван толгойн орд зэрэг орд газраараа хэн бүхний сонирхлыг татаж эхэлсэн.

ХБНГУ-ын тал ч мөн цаашдаа ч өсөх төлөвтэй байгаа ашигт малтмалын үнийн гэнэтийн өсөлтөөс өөрийгөө хамгаалахын тулд ардчилсан, харьцангуй найдвартай Монгол Улсад ашигт малтмалын орд газартай байх бодлогыг сонирхсон байж болох талтай бөгөөд 2006 онд ХБНГУ-ын зүгээс бодлогын өөрчлөлт гарч, Монгол Улстай харилцах харилцаанд мэдэгдэхүйц ач холбогдол өгч буй нь мэдрэгдэх болсон. 2006 оны 4 дүгээр сарын 3-4-ний өдрүүдэд Монгол Улс, ХБНГУ-ын Гадаад хэргийн яамд хоорондын зөвлөлдөх уулзалт болж, үүнд Монгол-Германы харилцаа бүхий л салбарт эрчимтэй хөгжиж буйг үндэслэн хоёр талын хооронд иж бүрэн түншлэлийн харилцаа тогтсон гэж үзсэний

зэрэгцээ Германы тал Монгол Улсын гурав дахь хөршийн бодлогыг сонирхон, Монгол Улстай гурав дахь хөршийн хэмжээнд харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд бэлэн байгаагаа мэдэгдсэн байна.³⁵

Үүний дараахан 2006 оны 5 дугаар сарын 31-нд ХБНГУ-ын Нордрайн-Вестфален муж улсын Эдийн засаг, дунд үйлдвэрлэл, эрчим хүчний яамны газрын дарга Рюдигер Блазегар ахлуулсан баг Монгол Улсад хүрэлцэн ирж, Монголын уул уурхайн өнөөгийн байдалтай танилцаж, хамтран ажиллах боломжийг судлах айлчлал хийсэн байна.³⁶ Тэд Багануурын уурхайн хүрэн нүүрснээс шатдаг хий гарган авах технологийг нэвтрүүлэх боломжийн талаар ярилцсан ажээ.³⁷ 2006 оны 9 дүгээр сарын 18-23-нд “Монгол, Германы уул уурхай, түүхий эдийн салбар дахь эдийн засгийн уулзалт” ХБНГУ-ын Бохум хотноо болж, түүнд Монгол Улсын Үйлдвэр, худалдааны сайд Б.Жаргалсайхан оролцсон байна. Хоёр талаас хүрэн нүүрснээс нефтийн бүтээгдэхүүн гаргах талаар санал солилцож, Монголд нүүрсний үйлдвэр байгуулах тухай ярилцсан байна.³⁸ Үүнээс үзэхэд Германчууд “Багануур” уурхайн хүрэн нүүрснээс шатдаг хий гаргаж авах технологийг Монголд нэвтрүүлж,³⁹ Таван толгойн нүүрсний ордод Германы алдарт “Сийменс” компаниар ахлуулсан олон улсын консорциум⁴⁰ ирж ажиллах хувилбар ирээдүйд байж магадгүй. Хэрэв энэ хувилбар хэрэгжиж чадвал Монгол Улс ХБНГУ-тай харилцан ашигтай хамтын ажиллагааны эхлэл тавигдах биз ээ.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Vertrag zwischen der Bundesrepublik Deutschland und der Deutschen Demokratischen Republik über die Herstellung der Einheit Deutschlands – Einigungsvertrag – vom 31.0.1990 (Auszüge), in: Deutsche Außenpolitik 1990/1991, Eine Dokumentation, S.164.
2. Botschaft von Bundeskanzler Dr.Kohl zum Tag der deutschen Einheit an alle Regierungen der Welt, mit denen das vereinte Deutschland diplomatische Beziehungen unterhält, vom 3.10.1990, in: Deutsche Außenpolitik 1990/1991, Eine Dokumentation, S.196.
3. Burghard Claus, Versuch einer Bestandsaufnahme und eines Ausblicks, in: Entwicklung und Zusammenarbeit, 4/1990, S.4.
4. Уламбаяр, Д., *Монгол, Өрнөдийн орнуудын харилцаа эрт, эдүгээ*, Улаанбаатар, 2004, 183-196 дугаар тал.
5. Außen- und sicherheitspolitische Aspekte der Deutschen Einheit, in: Deutsche Außenpolitik nach der Einheit 1990-1993, Eine Dokumentation, Bonn, 1994, S.423.
6. Цэрэнчимэд, Ц., “Монгол орны эдийн засаг”, *ҮНЭН*, 1996 оны 6 дугаар сарын 17, №70 (18521), 5, 6 дугаар тал.
7. *Ardyn Erch*, 28.12.1991.

8. БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, Үнэн, 1991 оны 1 дүгээр сарын 4-ны өдөр, №3 (17839), 2 дугаар тал; “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”, Үнэн, 1992 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, №106 (18139), 3 дугаар тал.
9. 1990 онд Нэгдсэн Германыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд 6 дахь гишүүнээр элсүүлэх саналыг ЗХУ-ын зүгээс гаргаж байсан бол 1991 онд АНУ-ын Ерөнхийлөгч Буш Partners in Leadership-т ХБНГУ-ыг оролцохыг урьсан байна.
10. Wichard Woyke, Die Außenpolitik des vereinten Deutschland- die dritte deutsche Republik auf der Suche nach einer Rolle im internationalen System, in: Politik und Wirtschaft am Ende des 20. Jahrhunderts, Opladen, 1995, S.35
11. “Die Sicherheitsinteressen der Europäischen Union sind vor allem im Zusammenhang mit der bislang noch hypothetischen Gefahr zunehmender politischer Instabilität in der Region zu sehen. Für die EU steht dabei mehr auf dem Spiele als bloß die Märkte und Investitionen. Wirtschaftlich gesehen könnte sich langfristig der Zugang zu den Ressourcen als noch bedeutenderer Faktor erweisen. Geopolitisch gesehen könnten Streitigkeiten zwischen einzelnen Nationalitäten oder regionalen Zusammenschlüssen sich zu Konflikten wie in Tadschikistan ausweiten, mit dem Risiko einer Einmischung von außen und schließlich der Möglichkeit einer Konfrontation mit Russland und dritten Ländern.” Mitteilung der Kommission, Die Beziehungen der Europäischen Union zu den neuen unabhängigen Staaten in Zentralasien, Kommission der Europäischen Gemeinschaften, Brüssel, den 10.10.1995, KOM (95) 206.
12. Мөн тэнд
13. Alexander Rahr, Ukraine, Kaukasus und Zentralasien: Wie die Europäer das “Great Game” verschlafen, In: KAS/ Auslandsinformationen, 8/05, Politik, Juli 2003, S. 4
14. Verteidigungspolitische Richtlinien für den Geschäftsbereich des Bundesministers der Verteidigung vom 26. November 1992 (Wortlaut), In: Blätter für deutsche und internationale Politik, №9’93, S. 1139
15. “Аюулгүй байдлын баталгаа-Клинтонд илгээлт явуулав”, Үнэн, 1993.11.15, №98 (18265), 1 дүгээр тал.
16. “Холбооны Ерөнхийлөгчийн хэлсэн үг”, Ардын эрх, 1995 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр.
17. Ардын эрх, 1995 оны 10 дугаар сарын 5-ны өдөр, №196(1155), “Ш.Содномжамц, Монголын офицеруудыг Германд сургана”, 2 дугаар тал.
18. Батчимэг, М., “Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага: Бүс нутгийн хамтын ажиллагааны шинэ загвар сэдэвт олон улсын бага хурлын тухай тэмдэглэл”, Стратеги Судлал, 3(27)2004, 134 дүгээр тал.

19. Мөн тэнд
20. “Гадаад харилцааны өргөн боломжийг дүүрэн ашиглая”, *Үнэн*, 1989 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр, №4(17221), 1 дүгээр тал.
21. Мөн тэнд
22. Гадаад харилцааны төв архив, ФН№70, Х/НН№76, Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатын ХБНГУ-д хийсэн айлчлал, 1995 он.
23. Гадаад харилцааны төв архив, ФН№70, Х/НН№110, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын ХБНГУ-д хийсэн айлчлалын материал, 2002-IV/21-26, II хэсэг
24. 1995 оны 9 сард П.Очирбат, 2000 оны 5 сард Н.Багабанди
25. 1992 оны 2 сард Ц.Бямбасүрэн, 2002 оны 4 сард Н.Энхбаяр, 2005 оны 6 сард Ц.Элбэгдорж
26. 1991 оны 6 сард Ц.Гомбосүрэн, 1997 оны 9 сард Р.Алтангэрэл, 1999 оны 9 сард Н.Туяа
27. 1993 оны 1 сард Н.Багабанди, 1996 оны 10 сард Р.Гончигдорж, 1997 оны 4 сард Р.Гончигдорж
28. 2001 оны 9 сард Ж.Бямбадорж, 2002 оны 2 сард Ж.Бямбадорж, 2003 оны 12 сард С.Төмөр-Очир
29. 2002 оны 3 сард Ж.Гүррагчаа
30. 1996 оны 5 сард Ц.Дашзэвэг, 1996 онд Г.Баасанхүү, 2002 онд Г.Баасанхүү
31. Д.Галсандорж, “Монгол, Германы худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал”, Эрхэлж хэвлүүлсэн Удо Б.Баркманн, П.Хайсандай, *Монгол-Германы харилцаа, Өнгөрсөн үе, эдүгээ, хэтийн төлөв*, Улаанбаатар, 2004 он, 98 дугаар тал.
32. Удо Б.Баркманн, “Монгол-Германы шинжлэх ухааны харилцаанд ГЭСА-ны гүйцэтгэсэн үүрэг”, *Герман: Судалгаа, мэдээлэл*, 1(7)2007.
33. Kurzstudie, Reserven, Ressourcen und Verfügbbarkeit von Energierohstoffen 2004, Stand 31.12.2004, Hrsg. Bundesanstalt für Geowissenschaften und Rohstoffe, S.4.
34. Grьnbuch, Eine europäische Strategie für nachhaltige, wettbewerbsfähige und sichere Energie, Brüssel, den 8. Mrz 2006, KOM (2006) 105 endgültig, Seite 4.
35. <http://www.mongolia-foreign-police.net/latestbig.php?id=187>
36. “Германы уул уурхайн салбарынхан Монголыг сонирхов”, *Ардын эрх*, 2006 оны 6 дугаар сарын 5-ны өдөр, 4 дүгээр тал.
37. Мөн тэнд
38. Даваадорж, Ц., “Томоохон төслүүдийг олон улсын баг хэрэгжүүлнэ”, *Өнөөдөр*, 02.10.2006, ЕЗ
39. “Германы уул уурхайн салбарынхан Монголыг сонирхов”, *Ардын эрх*, 05.06.2006, 4 дүгээр тал
40. Даваадорж, Ц., “Томоохон төслүүдийг олон улсын баг хэрэгжүүлнэ”, *Өнөөдөр*, 02.10.2006, ЕЗ